

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гонсын Гэндэндорж	Дугаар	L055
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Чойбалсан сум
Төрсөн газар	Дорнод аймгийн Чойбалсан сум	Төрсөн он	1921
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Данригданжайлин хийд	Сүм хийдийн дугаар	ДОЧХ 010
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 27	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Хэрлэн сумын Сан бэйсийн урд хүрээ

Та нутаг орондоо байсан өөрийн мэдэх хүрээ хийдийн тухайгаа ярьж өгөөч?

Сан бэйсийн хүрээний хойд хийд, тэрний урд талд бас нэг том хийд байсан юм. Хойд хийд нь хэдэн сүмтэй байсан юм бүү мэд. Очиж үзээгүй. Урдах нь 3 том сүмтэй. Гол сүм гэдэг том сүм байна. Тэр нь ер нь том доо том. Багана нь дөчийн бидон ч гэж ярихгүй дээ. Тийм бүдүүн бүдүүн баганатай. Их ээ том. Гадуураа болохоор чулуун шалтай. Тэгээд том хэрэмтэй чулуун байшин. Тэрний баруун талд нь Дүйнхорын дацан байсан. Тэр нь дөрвөлжин дацан байсан. Дандаа хүрэн тэрлэгтэй лам нар байсан. Түүнээс гадна Манба дацан гэж байна. Манба дацан гэдэг нь ухаандаа эмчийг гаргадаг дацан даа. Урд хүрээ бол Чойр дацантай. Урд хүрээний гол нь Чойр л доо.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Та өөрөө ямар дацанд нь хурж байсан бэ?

Цагтаа бас сууж байсан. 10 хэдтэй байхдаа. Урд хүрээнд сууж байсан.

-Сан бэйсийн хүрээний Урд хийд дээр?

Тийм. Сүүлдээ Хайлангийн сүм гэдэгт сууж байсан.

Ламын хийд бол гурван дацантай тийм хийд байсан даа. Хойд хүрээнд бол жүд гэдэг дацантай байсан. Тэгээд урьдын нэг хүн тэгж байсан гэж байгаа. За чи хүн шиг явъя гэвэл Жүдэд ороорой, хүнээ байя гэвэл Чойрт ор, хүн алъя гэвэл Манбад ороорой, хүүрчин болъё гэвэл Жодод ороорой гэж хэлдэг байсан.

-Та Чойрт аль зиндаа хүртэл явсан бэ?

Би Чойрт хурж байсан санаатайгаас биш тэр зиндаа хүрээгүй. Би ер ахиагүй хүн. Тэр ламын хийдэд Хайлан гэдэгт хурж байлаа.

-Ламын хийд чинь бас хоёр газар байсан болж таарах уу?

Хоёр газар.

-Нэг нь голын урд. Нэг нь голын ардаа юу?

Үгүй, үгүй голын урд байхгүй. Нэг нь том өндрийнхөө урд руу баахан чулуу байгаа. Нэг нь тэрнээс зүүн тийш. Овооны туурь байгаа. Тэнд байгаа. Тэр зүүн нь гурав нүүсэн гэсэн юм гэнэ лээ. Нэг нь манай энэ сумын хойд руу тэнд байсан. Нэг нь урагшаа яваад Хөгшин хүрээний бунхан гэж байгаа тэнд байсан. Голын хойд талд тэнд нэг байсан.

-Ялгуулсан ламын хийдийг хэлж байгаа биз дээ?

Тийм. Ялгуулсан лам гэдэг чинь 8-р дүр нь сууж байсан юм гэнэ лээ. Надаас ер нь 3 ах хүн юм уу даа. Урд хүрээний хувьд хошуу хурал гэж том хурал хурдаг байсан. Өвөлдөө яахав хурал хурна.

- Урд хүрээ гэдэг чинь Сан бэйсийн Урд хүрээ?

Тийм. Цам гэж гарахгүй. Дүйнхорын тэнд нэг цам гардаг ухаантай. Цам гэж 21 дарь эх гардаг юм. Манай энд ламын хийд гэж энэ Баруун хийд чинь их том хийд. Дуганууд нь одооны энэ дугануудтай харьцуулахад их том. Мундаг том байсан юм. Тэр одоо аймгийн их хүрээ чинь их хурал хурлаа гэхэд баруун талд нь хоёр мөр зүүн талд нь хоёр мөр тэрний ар талд хэнгэрэг. Лав л 10- с доошгүй хүн байсан. Голдоо бишгүүр гээд 4,4-өөр найман хүн сууна. Тэрний араас гандан гэж байна. Тэгээд хонх дамартай лам 6-с доошгүй дээ. Тэрний наана унзад нар гэж байна. Их унзад, бага унзад гээд байна. Зүүнд цогчэн гэсгүй гэж байна. Хоёр гэсгүй байдаг юм. Баруун талд нь Манба гэсгүй бас орж ирнэ. Тэгээд хурал хурна даа.

-Хошуу хуралд нь ямар хурал хурдаг байсан бэ?

Хошуу хурал чинь одоо чухам юу хурдагийг мэдэхгүй ээ. Хошуу хурлаар миний мэдэхийн Маанийн бүтээл хурдаг байсан. Маанийн бүтээл гээд өдөр шөнөгүй сунтаг бариулаад суулгачихдаг байсан.

- Маанийн бүтээлээ хэдэн өдөр хурж байсан бэ?

Би тэгэхэд жаахан байсан.

-Гурваас дээш хоног хурдаг байсан байх даа?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Янз бүр л байсан байх. За тэр ламын хийд гэдэг түүхтэй хийд ээ. Тэнд Ламын цам гэж гардаг байсан. Одоо их гоё. Баг нь их уртай. Араа шүд энэ тэр нь ер нь сүртэй дээ. Дандаа хоргойгоор урласан байсан. Оосортой. Урт хадгаар оосорлосон сувдан эрхтэй. 21 дарь эх гэж байсан. Тэр лав 21 байсан. Гортигон дотор битүү бүжиглэдэг байсан. Эхлээд жижиг бурханууд нь гарч ирнэ. Хойноос нь ах нар нь гарч ирнэ. Тэгээд бүр томчууд нь гарч ирнэ. Тэгж байж нэг жигдрэнэ. Тэгээд олон Хангалууд байна. Улаан сахиус, Чойжоо, Гонгор гээд. Бүгд гарч ирнэ.

**Монголын шашин аргагүй дээд цэгтээ хүрсэн юм даа. Өнөө яахав жаахан үзүүрийн юм байгаа юм.**

-Хэдүйд гардаг байсан бэ?

Намар л гарч байсан даа. Сүүл сарын 29-нд гарч байсан байх.

-Цамд хэдэн дүр гардаг байсан бол?

Өө. Тэрийг би мэдэхгүй. 100 гаран байлгүй дээ.

-Та тус тусад нь дүрийнх нь тоог санаж байна уу? Улаан сахиусны тэдэн дүр гээд?

Өө, Улаан сахиусны хор гэж титэг нь , улаан цамцтай цэвцийсэн цэвцийсэн бондгор бондгор хүүхдүүд гарч байсан юм даа. Хоёр найм 16

гарч байсан байх. Сайн мэдэхгүй байна. Би тэр үед 12, 13- тай л байсан үе дээ. Тэгээд Арван Хангал чинь бүгд гарч ирнэ дээ. Хамгийн сүүлд л Чойжоо гарч ирнэ дээ. Эхлээд хүний толгойн хувхай яс өмссөн 4 юм гарч ирнэ. Ухаандаа дөвчин хүн юм даа. Тэр хоёр гарч ирдэг юм. Дараа нь дөрвөн азар гэж гарч ирдэг юм. Үндсэндээ улсуудыг оруулахгүй барихгүй гэдэг. Цагаан өвгөн. Хашин хан гэж нэг том өвгөн гарч ирнэ. Том бурхануудыг гараад ирэхээр том хадаг бариад наанаас нь явна. Тэгээд Ламын цам гэдэг чинь өглөөнөөс орой болтол явна. Цамнаад л байна. Орой сэржим өргөнө. Орой тарах болохлоор бүх хорнууд гарна. Буга согоо гарна. Тэр хувцасны гоё гэдэг. Титэг нэг улаан хувцастай. Азар нэг улаан хувцастай. Тэр Цагаан өвгөн гэдэг чинь дундуур нь гарч ирээд хөгжөөдөг. Тийм юм уу даа.

-Сан бэйсийн хүрээний төвд нэр юу гэдэг байсан юм бол? Хэдэн онд байгуулагдсан юм бол?

Хойд, Урд хүрээ гэж байсан. Энд Ламын дээд, доод хүрээ гэж байсан. Ялгуулсны дээд, доод хүрээ гэж байсан. Тэрнээс баруунтш бас нэг хийд байсан. Суварганы хийд. Жамъянтүв лам барьж байгуулсан гэсэн.

-Дэчин гэгээний хийд үү?

Тийм. Тэр чинь нэг л их том өндөр суваргатай байсан. Тэр Жамъянтүвийн тухай цагаадсан гэж радиогоор ярьсан гэж энэ улс л яриад байгаа юм. Эсэргүү гээд 1936 онд чинь барьж эхэлсэн юм. Яагаад эсэргүү болчихсон юм гэхээрээ засаг төр үүсэж байхад зарим нь Оросыг дагана гээд. Зарим нь Японыг дагана гээд. Тэгээд Японыг дагана гэсэн нь эсэргүү болчихсон ш тээ. Өнөө Японтой ч найз, Хятадтай ч найз, Америктай ч найз, Оростой ч найз. Найзгүй улс байхгүй боллоо. Хуучин чинь энэ Америкийг мөн цусыг нь гартал мүүлж байжээ. За тэгээд Ламын хийд бол тийм том хийд байсан юм. 8-р Ялгуулсан гэдэг нь надаас одоо 3 ах юм даа.

-Сан бэйсийн хүрээ хэдэн онд байгуулагдсан юм бэ? Хойд урд хүрээ?

Өө, тэрийг яаж мэдэхэв. Мэдэхгүй.

-Төвд нэр нь юу гэдэг байсан юм бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Одоо миний л мэдэх Хойд хүрээ, Урд хүрээ л гэж ярьдаг байсан. Дээд өргөө, Доод өргөө гэж ярьдаг байсан. Харин Ламын хийдийг Дээд хийд, Доод хийд гэдэг байсан. Барууныг Гэгээний хийд гэдэг байсан.

-Сан бэйсийн хүрээнээс доошлоод ирэхээрээ Дэчин гэгээний хийд байна уу?

Тийм. Дэчин гэгээний хийд.

-Хөгшний хурал гэж хаана байсан юм бэ?

Хөгшин хүрээ гэдэг чинь миний түрүүний хэлдэг байх аа даа. Тэр Ламын доод хийд чинь нүүдэллэж яваад Хөгшин хүрээний бунхан гэдэг дээр ирж байгаа. Би Хөгшин хүрээ гэж дуулаагүй. Хөгшин хүрээний бунхан гэдэг бол тэр дээр үед хэдийд нь ч юм буусан юм. Замын хойхнотой шавар бий. Осолгүй л хийд байсан байна лээ. Яагаад гэвэл залуу байхдаа үгэнд дурлаж явж байхад тэнд сүмийн дээврийн шавар, туйпуу байна лээ. Сүмийн хашаанд зүүдэг байсан хонхны хагархай ганц нэг байсан. Айлуудынх нь байшин жаахан жаахан юм билээ. Нэг хоёр нэг хүн байдаг л гэлтэй. Тэрний баруунтшаа бас нүүсэн. Ламын доод хийд гурав нүүсэн юм гэсэн. Манайхны энд Чойсүрэн гэж Доод хийдэд лам байсан нэг өвгөн байсан.

-Ламын хийдийн одоо туурь байгаа газар нь юу гэдэг нэртэй газар байна?

Мөнхөдийн нуураас урагш, Хутаг уулаас баруун хойш. Голын хойно. Туурь нь байгаа даа.

-Хоёр хийд маань хоорондоо хэр зайтай байсан бэ?

Хоёр км байгаа биз дээ.

-Дээд хийд нь нэлээд том, олон дуган байсан болтой?

Оо, тийм. Их олон ламтай байсан. Доод хийдээс ч лам нар очдог байсан байх. Тэнд сүүлд цам гарсан болтой. Яагаад мэдэж байгаа гэхээр Угтам дархан гэж хүн байсан. Цамын баг хэрэглэлийг хийдэг. Тэр дарханы хөгшин гэж нэг хөгшин байсан. Тэр хөгшний хүүхэд юм байх маний үеийн нэг хүүхэн байсан. Нэлээн саяын юм билээ л дээ. Угтамын лам байсан. Угтамаас Бавуу чамбон гэдэг хүн ирж бүжгийг дэглэсэн юм гэж дуулсан. Бас Довчин чамбон гэж байсан.

-Тэр цамын бүжиг дэглэдэг улсуудаа чамбан гэдэг байсан юм байна?

Тийм, тийм. Тэр олон сайхан баг нар нэг газар хадгалаастай байдаггүй. Хачин юм аа. Тэгээд энэ Доод хийдийнх нь зүйлсийг шинжээч яваад баруун хойш нь нэг газар нүхэнд булчихсан юм аа даа. Хэдэн хүн яваад ухаад их юм олсон гэж сонссон. Одоо тэр урд хийд дээр бол хоёр мөнгөн бишгүүр байсан. Ламын хийдийн нэг тамга байдаг юм байна л даа. Одоо байдаг. Яагаад байдаг вэ гэхээр Дээд хийдийн юмыг шатааж, тэгээд тамга нь шатаагүй үлдсэн ч юм уу, тэрийг Содномваанчиг гэдэг хүн авчээ. Хадгалаад байсан. Содномваанчигийн үеийнх нь юм уу, зиндааных нь юм уу, Гунгаагийн Даржаа гэдэг хүн. Артелийн нярав байсан хүн. Тэгсэн Содномваанчиг энэ хожим хэрэгтэй болох байгаа. Чи энийг хадгалж байгаарай хийдийн тамга гэж өгсөн юм гэнэ лээ. Тэгээд хадгалж байсан. Манай сүмд хийд байгуулахад тэр тамгыг авчирч өгсөн. Одоо тамга нь байдаг л байх. Төвд үсэгтэй тамга байгаа биз дээ. Дөрвөлжин тамга. Угтамын хийдийн тамга ????????? 28-36

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Бид хуучин байсан сүм хийдүүдээ бүртгэсэн нэг мэдээ баримталж яваа. Профессор Б. Ринчен гуайн гаргасан. Тэнд энэ Хэрлэн, Баянтүмэн, Чойбалсан сүм гээд Хэрлэн голын хөвөө дагасан хийдүүдийг бүртгэсэн байгаа. Энд Чойбалсан суманд Дэчин гэгээний хийд гэж байна.

Дэчин гэгээний хийд гэдэг чинь Суварганы хийд.

-Ламын хийдийн хоёр түүриас аль зүгт байна?

Баруун тийш. Аймгийн төвөөс нааш. Хадан хошуу гэдгийн баруунтшаа жаахан толгой бий. Түүн дээр бий. Манай энэ Чойбалсан суманд чинь байгаа. Энэ чинь уг нь Очирбаянмөнх гэдэг нэртэй сүм байсан. Очирбаянмөнх гэдэг чинь улсаас анх засаг байгуулахад жижиг жижиг сумууд болсон юм байна. Сүмбэрийн сүм гэж нэг байгаа. Энэ хойд Дэлгэрмөнхийн сүм, энэ зүүнтээ Баян гэж тус тусдаа байсан. Тэгээд нэгтгэсэн. Тэгсэн манайх Сүмбэрээрээ байна, манайх Дэлгэрмөнхөөрөө байна гээд булаацалдаад байсан. Тэгээд Очир гэдэгт нь Сүмбэрийг нь оруулаад, Баян гэдэгт нь зүүнтшийнхийг нь оруулаад, Мөнх гэдэг нь Дэлгэрмөнхийнх. Ингээд Очирбаянмөнх сүм болсон юм. Тэрүүгээрээ байж байгаад Чойбалсангийн нэрээр Чойбалсан аймаг, Чойбалсан сүм гэдэг болсон.

- Дэчин гэгээний хийд маань Хадан хошуунаасаа баруун тийшээ байна уу?

Тийм. Хадан хошуунаасаа баруун тийшээ. Аймаг явах чигт л байгаа.

-Таны санаж байгаагаар сүүлд тэр хавьд юу байгуулагдсан бэ?

Тэнд чинь гахайн байр байсан юм. 3-р фермийн гахайн байр тэнд байсан юм.

- Гахайн байрны хаанаа вэ?

Гахайн байрны яг хаана нь юм бүү мэд ээ. Ер нь жаахан төвгөр газар байгаа. Бас нэг жаахан хундаам энэ тэр байдаг юм болов уу? Гахайн байр гээд чулууг нь бас аваа биз дээ.

-Ялгуулсан хутагтын хийд гэж байна?

Энэ чинь одоо Дээд, Доод хийд шүү дээ.

-Хөгшний хүрээ гэж Ялгуулсанахаа Доод хүрээг хэлж байсан уу? Доод хийд нүүж явахдаа буусан гээд байгаа?

Аа тийм. Нэг нь сумаас хойш Жононгийн овооны тэнд буусан, дараа нь Хөгшний хүрээний бунхан гэдэгт буусан гэж байгаа. Эвдэрхий сүм гэж байхгүй биз?

-Байхгүй байна. Гурван баяны хийд гэж байна?

Гурван баяны хийд ч гэхээд юм байхгүй дээ. Хөдөөгүүр чинь отгууд хоорондоо хуралтай байсан юм. Манайхны энд Булганыг тахидаг улсууд Дөчийн Манлын хурал гэж байсан. Тэнд очиж махыг нь идэж л байлаа.

-Энэ хурал юу гэдэг газар байна?

Булганаас хойш. Баяншугуйгаас зүүн хойш тохойд байдаг юм даа. Баяншугуй гэж Булганы зүүн хойд талын битүү бургасыг хэлдэг юм. Бат овооноос хойш. Голынхоо хойд биед байсан. Тэр одоо ор байхгүй ээ. Намар лам нар хөдөөлчихсэн. Том том лам нар очсон бүрээ бишгүүртэй хангинасан том хурал болдог байсан. Нэг байшинтай. Цагийн хурал. За тэр Баяны хурал гэж Гурван баяны үрд байсан юм гэнэ лээ. Тэр чинь зун, намартаа хурдаг цагийн хуралтай газар байсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Талбайн тайж нарын хурал гэж?

Одоо тэр Гурван баяны хурал л байх даа. Өөр хурал байхгүй дээ. Би дуулаагүй. Тэрнээс нааш Эвдэрхий сүм гэж байсан.

-Тэр Эвдэрхий сүм гэдэг чинь хаана байсан юм бэ?

Голоосоо урагшаа эргэсэн тохойд байсан. Сүмийн хоолой гэж нэг сүмийн ор бий. Тэрийг би мэдэхгүй. Манайхны энд гэдгэр Гомбо гэдэг нэг настай хүн байсан. Өнөө байвал нэг 130-аад насны хүн байна. Би Гомбо гуайгаас энэ ямар сүм байсан гэж Эвдэрхий сүмийг асуусан. Мэдэхгүй би хурганд явж байхад л ийм юм байсан. Ийм л юм байсан гэж хэлж байсан.

- Талбайн тайж нарын хурал гэж нэг хурал байна. Энэ Хэрлэн голынхоо хойд дээр байсан байгаа.

Тэгвэл тэр миний хэлээд байгаа Гурван баяны хурал л байх даа. Цагаан лам гэдэг нэг хүн байсан юм гэнэ лээ. Бүргэдийн Цагаан лам гэж. Тэр бас амаргүй лам, хийдтэй байсан гэж дуулсан. Хаана ямар хийдтэй байсныг мэдэхгүй. Гурван баяны хийд гэж дуулсан. Очиж үзээгүй. Сүүлд явж байхад сүмийн дээврийн ваар энэ тэр байсныг харсан.

-Яг Гурван Баяныхаа өвөрт байна уу?

Гурван Баянаасаа арай дээш. Баруун Баяны дунд байсан байх. Одоо тэнд чинь Сүхбаатарын дурсгалын хөшөө гэнэ үү, жаахан дөрвөлжин юм бий. Сүхбаатар явж байсан юм гэнэ лээ.

-Еншөөв хурал гэж дуулсан уу?

Аа дуулсан. Чухам хаана байсныг мэдэхгүй. Еншөөв хурал гэж урагшаа л байсан болов уу? Ер нь мэдэх хүн байхгүй л байх даа. Халзан Бадарч гэдэг хүн байгаа. Тэрний авгайнх нь эцэг гэж нэг настай хүн байдаг юм. Тэр хүн нэг гадарлавал гадарлах байх.

-Мээрэнгийн хурал гэж байсан байна?

Мээрэнгийн?

-Тийм ээ, Мээрэнгийн хурал. Эрэг шанд гэдэг газар байсан байна. Энэ Энгэр шанд гэдэг газраа Эрэг шанд гэж тэмдэглэсэн байх.

Тийм байж болно. Энгэр шанд гэж бий. Эрэг шанд гэж нэртэй газар байхгүй.

-Энэ газар сумын төвөөс багцаагаар хойд зүгт байна?

Тэгвэл Энгэр Шанданд байсан юм байгаа биз дээ. Би тэнд хурал байсан гэж дуулаагүй. Захирагчийн суурин гэж их том баян хүн байсан гэж дуулсан. Тэр баян бас нэг жаахан хийд бариулсан юм байгаа биз дээ.

-Бид нар туурин дээр нь очлоо л доо. Нэлээн том хэрэмтэй, туурь байна.

Тэр газраа байшингийн суурь байна уу?

-Байна. 4,5 суурь байна.

Янз бүрийн чулуу байна уу?

-Голынх нь суурин дээр хөх тоосго байна лээ.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

За тэгвэл энд байсан юм байлгүй дээ. Урдын баячууд бас хийд хуралтай байдаг байсан гэсэн. Чухам энийг би тийм байсан гэж дуулаагүй. Захирагчийн суурин л гэж мэднэ. Мээрэнгийн хийд гэнэ үү?

-Тийм ээ, Мээрэнгийн хурал гэж байна.

Захирагч Мээрэн гэдэг байсан юм байх даа.

-За нэг ийм ийм л хийдүүдийн нэрс байгаа юм даа. Баянтүмэнгээс баруун тийш нэг хоёр хийд олдохгүй байна. Юмын хурал, Хүйн хурал гэж?

-Тэрийг мэдэхгүй. Аймгийн хошуу хурлаас илүү том хурал байгаагүй байх. Би л лав тэнд хурал байна гэж дуулаагүй. Энэ ойр Загалынхан, Дашбалбарынхан, Хөгнө сум тэгээд манай сум гээд Хошуу хуралд л очдог байсан. Аймгий Хошуу хурал гэдэг чинь учраа алдсан олон ламтай байсан байна.

-Сан бэйсийн хүрээний Хойд, Урд хоёр хийд маань хэдэн ламтай байсан юм бэ?

Лав л Хошуу хуралаа хурахлаар 1000 гаран лам байсан байх. Нарийн хуралд нэг 700, 800. Жижиг тусгай хуралд 400, 500 багцаатай байсан байх. Багтдаггүй байсан юм гэнэ лээ. Тэгээд гадаа нь суудаг байсан гэсэн. Тэр сум ер нь их зайтай. Тэгээд гадаа сууна гэхээр учраа алдсан олон болно. Урдын хийд чинь мундаг аа. Чийг мод гэж хоёр өндөр мод байна. Эзэн хааны морийг уядаг уяа байна. Хийдэд сэнтий гэж байна. Тэр суудалд хэн суух вэ гэхээр эзэн хаан сууна.

-Сэнтийд тэгээд хэн суудаг байсан юм бэ? Хошуу ноён уу?

Улсын эзэн хаан сууна. Богд эзэн.

-Ламын хийд хэдэн онд байгуулагдсан юм бэ?

Ёстой мэдэхгүй.

-Ламын Дээд хийд хэдэн ламтай байсан бэ?

500, 600 лам байсан байлгүй.

-Ламын Дээд хийд хэдэн дугантай байсан бэ?

Үгүй ээ, нэг их олон дуган байгаагүй байх аа. Харин Урд хийд нь олон дугантай даа. Гол сум, Дүйнхорын дацан, Манба дацан гэсэн дацангууд байсан. 4 аймгийн дуган байсан. Баруун урд аймаг, Баруун хойд аймаг Зүүн хойд аймаг, Зүүн урд аймаг гээд. Дандаа давхартай сүмтэй. Нэг сүмд нэг 100-аад хүн суухад багтах тийм байсан. Лав л Зүүн урд аймаг тийм байсан. Би ахтайгаа цуг Зүүн урд аймагт байсан. Тэгээд хуралд нь сууж үзэж байсан. Би гол төлөв аймгийн хурал хурахад сууж байсан. Тэгэхэд ер нь 5, 6 хэнгэрэг байсан. Нэг л том хурал байсан. Өвлийн том хурлын хөгжим нь маягтай. За Майдар эргэнэ гэнэ.

-Ламын Дээд хийд хэдэн дугантай байсан бэ? Туурь нь их л том туурь үлдсэн байна лээ.

Нэг хийд байсан. Хойноо нэг байсан. 2-с илүү дуган байгаагүй дээ. Лам нарын байшингийн туурь олон бий. Урдуураа жаахан. Дундуураа чөлөөтэй.(зайтай) Баруун урдаа нэг хэсэг нь, тэр чөлөөний хойно байгаа чинь хурлын газрынх нь туурь. Лам нарын байр нь хоёр талаараа байсан. Тэр чөлөөний хоёр талаар байсан.

-Ламын Доод хийд нь хэдэн дугантай байсан бэ?

Доод хийд олон дуган байхгүй. Хойноо нэг шавар дугантай. Урдаа нэг шавар гэртэй.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Баянцагааны зүүн хойд дор нэг туурь байдаг. Тэнд хийд байсан уу?

Би мэдэхгүй. Наймаа нар урдаас орж ирээд жижиг жижиг байшин бариад л байсан тал бас бий. Тэр чухам хийд гэдгийг бүү мэд.

-Ер нь тэгээд наймаа нар чинь сүм хийд хүрээг бараадаж л байсан байх даа?

Тийм биз дээ.

-Та энэ хийдүүдийн сахиусыг хэлж өгөөч? Ямар ямар сахиустай байсан бэ?

Одоо тэрийг мэдэхгүй юм. Ламын хоёр хийд тус тусдаа сахиустай байсан. Доод хийд чинь Улааны урсгал байсан гэсэн.

Дамдин Бишрэлтийн шороо гэж бөөгийн онгодыг дардаг шороо байдаг гэсэн. Манай нэг өвгөн байсан. Тэр баруугаар бадарчлаад явдаг гэнэ. Тэгсэн нэг айлд орсон. Энэ урд айлд өнөө орой сахиус бууна гэнээ. Бөө бөөлөх юм гэнэ. Тэнд очиж гэнэ. Өнөө бадарчин өвгөнд Дамдин Бишрэлтийн шороо байсан юм байж. Улс ч их цуглаж. Баруун гэрт нь өвчтэй хүн байна гэнэ. Тэгээд бөөгийн онгод ороогүй гэсэн. Мундаг мундаг хүмүүс их байсан юм байна лээ. Баруун аймагт Дилав хутагт гэж байсан. Манайхны энэ Ялгуулсан хутагт гэдгийн чинь тухай би нэг домог сонссон. Хувилгаадыг аваачиж шалгадаг юм биз дээ. Очсон нэг цийдэм хийж өгсөн юм байна. Ялгуулсан үлээчихсэн. Сүүг нь нэг, усыг нь нэг ялгасан байна. Тэгээд Ялгуулсан гэж нэр авсан юм гэж. Тэгээд Захын Ялгасан нэртэй болсон.

-Та 1990 оноос хойш хуралд хурав уу?

Би багадаа хэдэн магтаалтай байсан юм. 6 ерөөлийнхөө нэгийг олохгүй болчоод байна. Чогжү Жалбо, Цагни Жанчив, Санжа Гонза, Санжид моллом, Түгжад тэгээд нэг нь байхгүй.

-Гиваанди

15,16-тай байхдаа л заалгаж байсан. Тэгээд 1990 оноос хойш энэ шашин мандаад монгол, төвд бичиг чөлөөтэй боллоо. Тэгээд унших гэсэн яг үсгээ бол мэднэ. Холбож гаргахгүй байна. Би хуралд хураагүй. Хурах маань ч яамай. Намын гишүүн хүн чинь.

-Эвдэрхий сүм гэдэг хийдийнхээ туурь байгаа газрыг та хэлээд өгөөч?

Сүмийн хоолойд.

Сүмийн хоолой нь хаана байдаг газар вэ?

Тэр зүүнтээ. Голын зүүнтээ байгаа.